# Хүний нөөцийн хөгжлийн систем – хэрэглэгчийн гарын авлага




## БАГЦ ЦАГААР ЛИЦЕНЗИЙН ХҮСЭЛТ ИЛГЭЭХ

Системд хандах линк:

http://hr.hdc.gov.mn/

**Бүртгэлтэй хэрэглэгч:**

Хэрэв өмнө нь бүртгүүлчихсэн бол
“Нэвтрэх нэр”- хэсэгт регистрийн дугаар

“Нууц үг” – Өөрийн бүртгүүлэхдээ үүсгэсэн нууц үгийг оруулах.

**Бүртгүүлэх** товч дарж бүртгүүлэх хуудас руу шилжинэ.

Шинэ хэрэглэгч та **Заавар харах** дарж заавартай танилцана уу /Нэвтэрсний дараа “Тусламж” цэснээс бусад заавартай танилцаарай/

# БҮРТГЭЛ ҮҮСГЭХ ХУРААНГУЙ ЗААВАР

1. http://hr.hdc.gov.mn/ хаягаар нэвтэрч “Бүртгүүлэх” дарж бүртгүүлнэ /бүртгэлтэй бол дахин бүртгүүлэхгүй/
2. “Регистрийн дугаар”, “Эцэг эхийн нэр”, “Өөрийн нэр”, “Утасны дугаар”, “И-мэйл хаяг” /өөрийн ашиглагддаг хаягаа оруулах-нууц үгээ мартсан тохиолдолд регистр, бүртгэлтэй и-майл хаягаар хүсэлт гарган шинэ нууц үгээ и-мэйл хаягаар авна/, “нууц үг”, “нууц үг баталгаажуулах” /өөрийн мартахгүй байх нууц үг зохиож үүсгэнэ/ зэрэг талбарыг Монгол хэлээр алдаагүй бөглөж, “үйлчилгээний нөхцөл” хэсгийг чагталсны дараа БҮРТГҮҮЛЭХ товчийг дарж бүртгүүлнэ.
3. НЭВТРЭХ товчлуур дарж нэвтрэх нэр хэсэгт өөрийн регистрийн дугаар, нууц үг хэсэгт өөрийн зохиосон нууц үгийг бичиж системд нэвтрэн орно.
4. Баруун дээд хэсэгт байх өөрийн нэр дээр дарж “Миний мэдээлэл” хэсгийг сонгож нээнэ.
5. “Ерөнхий мэдээлэл” хэсэгт байх “Мэдээлэл шинэчлэх” товчийг дарснаар таны мэдээлэл ХУР системээс баталгаажин ногоон өнгөтэй болно. /Жич: овог нэрийг алдаатай эсвэл латинаар бичсэн, бичиж дуусаад зай авсан тохиолдолд ХУР системтэй таарахгүй болно/
6. Програмд дахин нэвтрэн орж бөглөгдөөгүй талбарын мэдээллийг бүрэн бөглөнө. /цээж зураг хэсэгт албан ёсны эгц өөдөөс харсан, албан хувцастай зураг оруулна/
7. “Мэргэжил” гэсэн цонхыг дарж “Мэргэжил”, “Дипломын дугаар”, “Тушаалын огноо”/захирлын тушаал/, “Зардлын хэлбэр”, “Төгссөн сургууль” зэргийг сонгож хавсралт хэсэгт өөрийн дипломыг дүнгийн хавсралтын хамт **PDF** хэлбэрээр оруулж хадгална. /Монгол тал байхад болно/
8. Үндсэн болон төрөлжсөн, мэргэжил дээшлүүлэх сургалтаа мөн адил талбар бүрийн ард байх **+ товч** дарж бөглөнө.
9. Ажлын туршлагаа бөглөж, нотлох баримыг PDF-ээр хавсаргана /Өмнөх ажилласан туршлагаа бүрэн оруулна/
10. Таны ажлын туршлагыг танай ажил олгогч байгууллагын хүний нөөц баталгаажуулах үүрэгтэй.
11. Уг бүртгэл нь зөвхөн нэг удаа үүсгэх бөгөөд цаашид өөрчлөлтийн мэдээллээ оруулаад явна.
12. “**Ерөнхий мэдээлэл**”, “**Мэргэжил**”, “**Ажлын туршлага**” , “**Мэргэжлийн зэрэг**” бөглөөгүй бол үйлчилгээ авах боломжгүй.

**Бүртгэл үүсгэх дэлгэрэнгүй заавартай танилцаарай**

# Лицензийн хүсэлт илгээх

**Багц цагаар сунгах**

- Бүртгэлийн мэдээллийг бүрэн бөглөсөн ажилтан **“Сургалт”** хэсгийн **“Системийн бус сургалт”** дээр он тус бүрээр хамрагдсан үндсэн, төрөлжсөн, мэргэжил дээшлүүлэх, багц цагийн аль сургалтын төрөл болох, кредит, хамрагдсан хугацаа зэрэг мэдээллийг оруулж, хавсралт хэсэгт нотлох гэрчилгээг **PDF** файлаар оруулж өгнө.
- **“Дүйцүүлэх материал”** хэсэгт 2015 оны ЭМСайдын 98-р журмын “Багц цагийн бүрдүүлэлт” хүснэгтийн оноо тооцох аргачлалын дагуу багц цаг дүйцүүлэн тооцох тул оролцсон бусад төрлийн сургалт, судалгаа, бүтээл байгаа бол тохирох нэрийг сонгон, нотлох баримтаа **PDF** файлаар оруулж өгнө.

**Тайлангаар сунгах** /25 ба түүнээс дээш жил мэргэжлээрээ ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтэн/

- 25 ба түүнээс дээш жил ажилласан тайлангаар лицензээ сунгах эмнэлгийн мэргэжилтэн сүүлийн 5-н жилийн тайланг **“Дүйцүүлэх материал”**-ын “Сүүлийн 5 жилийн ажлын тайлан” сонголтод **PDF** файлаар оруулж өгнө.

**Төлбөр, зураг**

- **“Дүйцүүлэх материал”** хэсэгт тэмдэгтийн хураамж төлсөн баримтаа харгалзах сонголтод оруулна /Хүний их эмч 2 жилийн лиценз 10000 төгрөг, бусад эмнэлгийн мэргэжилтэн 5000 төгрөг/. Тэмдэгтийн хураамжийг Банкаар болон интернэт банк, ЭМХТ-ийн I, II-дугаар байрны нэг давхарт төлж болно.
- Зөвшөөрлийг үнэт цаасаар хэвлэх тул ажлын 5 өдөрт багтаан цээж зургаа ЭМХТ-ийн 1 дүгээр байрны 102 тоотод авчирч өгнө. /овог нэр, регистерийн дугаар, утасны дугаараа гаргацтай бичиж явуулах/. Шуудангаар илгээж болно.

**Хүсэлт илгээх**

- **“Лиценз”** хэсгийн “Лиценз шалгах” дарахад хүчинтэй лиценз гарна. Хүчинтэй хугацаа дуусахаас 1 сарын өмнө хүсэлт өгнө.
- “Лиценз” хэсэгт **“Лицензийн хүсэлт”** гэсэн цэнхэр товч дээр дарж өөрт тохирох “Багц цаг”, “Тайлан” сонголтыг сонгоно.
- Өмнө оруулсан багц цаг тооцуулах материалуудаа сонгон зөвлөсний дараа **ИЛГЭЭХ** товч дарж хүсэлтээ явуулна. /Их эмч, эм зүйч жилийн 6 багц цаг, Сувилагч, тусгай мэргэжилтэн жилийн 3 багц цаг байна/.
- Зөвшөөрлийн хүсэлт илгээсний дараа лиценз дуусах хугацаанаас хамаарч хариуцсан мэргэжилтэн шалгаж хариуг илгээнэ.

# **Миний мэдээлэл –**хүсэлт илгээхийн өмнө мэдээллээ шинэчлээрэй


Б.Батням

Б.Батням

Мэдээлэл

Зарлал

Тусламж

Ерөнхий мэдээлэл | Мэргэжил | Ажлын туршлага | Боловсрол | Лиценз | Зэрэг | Сургалт | Гишүүнчлэл | Шалгалт | Дүйцүүлэх материал | НД лавлагаа

**Мэргэжил**

| Мэргэжил | Тушаалын дугаар | Огноо | Суралцсан улс | Байгууллага | Зардлын хэлбэр | Хавсралт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хүний их эмч | Тушаалын дугаар | 2021-07-02 | Монгол | Улсын гуравдугаар төв эмнэлэг | Хувийн | | |

**Үндсэн мэргэжил**

| Үндсэн мэргэжил | Тушаалын дугаар | Огноо | Суралцсан улс | Байгууллага | Зардлын хэлбэр | Хавсралт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Дүрс оношилгоо судлал | Тушаалын дугаар | 2018-07-11 | Монгол | Улсын гуравдугаар төв эмнэлэг | Хувийн | | |

**Төрөлжсөн мэргэжил**

| Төрөлжсөн мэргэжил | Тушаалын дугаар | Огноо | Суралцсан улс | Байгууллага | Зардлын хэлбэр | Хавсралт | |
|---|---|---|---|---|---|---|---|

**Дээшлүүлэх**

| Дээшлүүлэх | Тушаалын дугаар | Огноо | Суралцсан улс | Байгууллага | Зардлын хэлбэр | Хавсралт | |
|---|---|---|---|---|---|---|---|

Тухайн жилд дүүргэсэн Сургууль, Үндсэн мэргэшил, төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалт, магистр, докторын сургалтаар багц цаг дүйцүүлэн тооцох тул хүсэлт илгээхээс өмнө мэдээллээ оруулаад **“Дүйцүүлэх материал”** цэсэнд хавсралтын хамт **ДАХИН НЭМЖ** өгнө.

# Миний мэдээлэл – Мэргэжил | мэргэжил нэмэх




**1.** Мэргэжил, үндсэн мэргэшил, төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтын харгалзах **+** - товчийг дараад **Зураг2**-т харуулсан цонх нээгдэх ба харгалзах утгуудыг бөглөж, сонгоод **Хадгалах** дарснаар мэргэжил нэмэгдэнэ.




| | | |
|---|---|---|
| **2.** | Мэргэжил: | Эзэмшсэн мэргэжлээ сонгох |
| | Тушаалын дугаар : | Тушаалын дугаар оруулах /*заавал биш*/ |
| **3.** | Тушаалын огноо: | Тушаал гарсан огноог оруулах |
| **4.** | Зардлын хэлбэр: | Хувийн \| Улсын \| Төсөл, хөтөлрийн гэсэн 3н сонголтоос сонгох |
| **5.** | Суралцсан улс: | Мэргэжил эзэмшсэн улсаа сонгох. |
| **6.** | Байгууллага: | Байгууллага сонгох /хэрэв гадаадад мэргэжил эзэмшсэн бол бичиж оруулах боломжтой./ |
| **7.** | Хавсралт: | Таны мэргэжлийн зэргийг нотлох хуулбар баримтыг PDF-ээр оруулах. |

**8.** дээрхи мэдээллүүдийг оруулснаар **Хадгалах** товч дарснаар таны мэдээлэл хадгалагдана.

# Лиценз| Багц цагаар лицензийн хүсэлт илгээх.




Зураг 1

**Алхам 1.**

**Миний мэдээлэл – Сургалт : Системийн сургалт** хэсэгт дарж орно.
Лицензийн хүсэлт илгээх товч дарна.




Зураг 2

**Алхам 2.**

Лицензийн хүсэлт илгээх цонх нээгдэх ба **БАГЦ ЦАГ** товчийг дарна.

# **Миний мэдээлэл –** Сургалт| Багц цагийн гэрчилгээ оруулах







**Өмнө хамрагдсан системийн бус сургалт системд оруулах**

1. **Нэмэх** товч дарах — /**Зураг 2**-т харуулсан цонх нээгдэнэ./
2. Суралцсан улс: — Суралцсан улсаа сонгоно.
3. Байгууллага: — Улс нь монгол бол дотоодын сургалтын байгуулагаас сонгоно. /Гадаад бол бол өөрөө бичих боломжтой/
4. Сургалтын нэр: — Суралцсан сургалтын нэрээ бичиж оруулна.
5. Сургалтын кредит: — Тоон утгаар оруулах
6. Үндсэн мэргэжил
   Төрөлжсөн мэргэжил
   Дэвшүүлэх : — Тухайн сургалт мэргэшлийн аль чиглэлд багтах болохыг тодотгоно.
7. Сургалтын хугацаа: — Сургалт эхэлсэн, дууссан хугацааг сонгож оруулна.
8. Тайлбар: — Шаардлагатай тохиолдолд нэмэлт тайлбар оруулах боломжтой /заавал биш/
9. Хавсралт: — Сургалт амжилттай дүүргэсэн гэрчилгээ, материалыг хавсралтаар зураг эсвэл PDF-ээр оруулна.

дээрхи мэдээллүүдийг оруулснаар **Хадгалах** товч дарснаар таны мэдээлэл хадгалагдана.

# **Лиценз**| Багц цагт Дүйцүүлэх материал оруулах




**Алхам 3.**

**1.** товч дарахад дүйцүүлэх материал оруулах **Зураг 2**-т харуулсан цонх нээгдэнэ.

**2.** Материалын нэр: сонголтыг даран **Зураг 3**-т харуулсан цонх нээгдэхэд дүйцүүлэх материалын жагсаалтаас өөрийн оруулах материалын нэрийг сонгоно /дүйцүүлэх материал тус бүрийн ард тооцож болох багц цагийн хэмжээг тэмдэглэсэн байгаа/.

**3.** Тайлбар: Тухайн оруулах материал нь дүйцүүлэх материалын шаардлага хангаж байгаа талаар тайлбар оруулж болно.

**4.** Хамаарах огноо: Багц цаг сунгуулах хугацаанд багтаж байгааг баталгаажуулан материалыг огноог бичнэ.

**5.** Хавсралт: Тухайн материалыг бүтнээр нь PDF-ээр оруулна.

Дээрхи мэдээллүүдийг оруулснаар **Хадгалах** товч дарснаар таны мэдээлэл хадгалагдана.

# **Лиценз|** Багц цагаар лицензийн хүсэлт илгээх. (үргэлжлэл)




**Алхам 4.**

1. Лицензийн төрөл: Сонгох /зурагт эмчлэх сонгосон./
2. Лицензийн дэд төрөл: Сонгох /зурагт хүний их эмч сонгосон./
   Сунгах жил : Тухайн мэргэжлийн лиценз 5 жил байх ба өөрчилж болохгүй
3. Системийн бус сургалт: Та өөрийн оруулсан мэдээллээ сонгоно.
4. Системийн сургалт: Дүүргэсэн сургалтууд, дүйцүүлэх материалуудыг жагсаалтаас сонгоно.

Таны сонгосон сургалтуудын нийт кредит нь **Нийт цуглуулсан кредит**-ын тоо болох бөгөөд Их эмч дээд мэргэжилтэнд 30, сувилагч бусад мэргэжилтэнд 15 хүртэл байх ёстой.

5. Хүсэлт илгээх: Дээрхи мэдээллүүдийг сонгоод хүсэлт илгээх товчыг дарснаар баталгаажуулах цонх нээгдэх ба **6.** OK дарснаар илгээгдэнэ. /**зураг2**/



# Лиценз| Багц цагаар лицензийн хүсэлт илгээгдлээ.




Таны хүсэлтийн Хүлээн авсан, Татгалзсан гэсэн үндсэн төлвүүдтэй болох болно.

Админаас хүсэлтэд хариу өгсөн бол илгээм ирэх ба дарж орсноор төлөв солигдсон байх болно./**зураг2**/




Таны хүсэлт амжилттай илгээгдсэн бол **Хүлээн аваагүй** төлөвтэй харагдаж байна.

# Төлбөр төлөх

**Шалгалтад тэнцсэн тохиолдолд**

Та шалгалтад тэнцсэн бол **5 хоногийн дотор** 3x4 хэмжээтэй 1 хувь цээж зурагаа /сүүлийн 2 сарын хугацаанд авахуулсан эгц урдаас харсан, албан хувцастай/ Эрүүл мэндийн хөгжлийн төвийн I байрны 102 тоот өрөөнд хүлээлгэн өгнө.

Хэрэв материал бүрдүүлж өгөөгүй тохиолдолд таны зөвшөөрлийн гэрчилгээ **гарахгүй болохыг анхаарна уу**.




Цээж зураг, тэмдэгтийн хураамжийг шуудангаар илгээж болно.
Зургийн хамт овог нэр, регистерийн дугаар, утасны дугаар, шалгалт өгсөн огноо, дүнг гаргацтай бичнэ.
**Хаяг:** Улаанбаатар хот-210648, Ш/Х-187, Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо, Энхтайвны гудамж-13Б

Тэмдэгтийн хураамжийг ЭМХТ-ийн I, II-дугаар байрны нэг давхарт байрлуулсан төхөөрөмжөөр төлбөрөө төлөх боломжтой.
Банк, интернет банкаар төлбөрөө төлж болно.

# Лиценз| Лицензтэй боллоо.







Таны лицензийн хүсэл хүлээн аваад, сайдын тушаал гарснаар лицензийн мэргэжилтэн “Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв”-өөс сайдын тушаалын дугаар оруулснаар та эмчлэх лицензтэй болох юм.

**Лицензийн дугаар** дээр дарснаар хэвлэх боломжтой зурган байдлаар харагдах юм.

**Хэвлэх товч** дараат та хэвлэж авах боломжтой юм. QR кодыг уншуулаад мөн харах боломжтой цахим лицензтэй болох юм.

**Анхаарал тавьсанд баярлалаа.**



# Заавартай бүрэн танилцсан танд баярлалаа

Бид төрийн үйлчилгээг
цаасгүй,
үүдгүйгээр үзүүлнэ.

www.hr.hdc.gov.mn